



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ  
АЛТАЙ-УЛИАСТАЙН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/50

Алтай хот

Захирлуудад 02 дугаар сарын  
үр дүнгийн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Систем компанийн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.11, Ажиллагсад сарын ажлын үр дүнгээр урамшуулал олгох журам, Систем компаний захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Салбарын дарга, охин компаниудын гүйцэтгэх захирлуудын 2019 оны 02 дугаар сарын гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж, Завхан салбарын дарга Г.Бадамхатанд үндсэн цалингийн 28 хувиар, "Тайшир-Гуулин УЦС" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Амартүвшинд үндсэн цалингийн 30 хувиар, "Богдын голын УЦС" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Улам-Оргиход үндсэн цалингийн 30 хувиар, "Тосонцэнгэлийн УЦС" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэгт үндсэн цалингийн 28 хувиар тус тус тооцон үр дүнгийн урамшуулал олгосугай.

2. Урамшуулалт цалинг тооцож холбогдох зардлаас гаргахыг салбар, охин компаниудын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



А.ПҮРЭВСҮРЭН